



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/620.

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.1.1.2, 1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өсвөрийн шатарчдын Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдын зардалд 5,000,000 (таван сая), Я.Жаргалын “Ерэн намрын шүүдэр” шүлгийн номын эмхэтгэлийн зардалд 500,000 (таван зуун мянга), “Уяачид дуулж байна” Улсын 3 дугаар уралдаанд оролцогч Нарийтээл сумын харьяат Р.Сугарт 300,000 (гурван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дээрх 5,800,000 (таван сая найман зуун мянга) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101319